



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020 07 28 № 117
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгуулагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн

015030678

тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль"-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын мөрийн хөтөлбөр / ... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны
сонгуульд оролцох Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл Намын



Ерөнхий зүйл: УИХ-н 2020 оны ээлжит сонгуульд “ШИНЭ нам, Бүгд Найрамдах нам, Үнэн ба Зөв нам, Монгол Үндэсний Ардчилсан намуудын ШИНЭ ЭВСЭЛ”-ээс дэвшүүлсэн “ШИНЭ ЭРГЭЛТИЙН БОДЛОГО-21” мөрийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхийг үндсэн зорилтоо болгон ажиллана.

Хамтдаа хөгжих 10 зорилт:

1. Орон нутагт намчирхал, талцалыг таслан зогсооно.
2. Орон нутгийн төсвийн зарцуулалтад хатуу хяналт тогтооно.
3. Аливаа асуудал, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхдээ тухайн орон нутгийн иргэдэд мэдээллийг урьдчилан танилцуулж, нээлттэй, өргөн хэлэлцүүлэг хийсний дараа шийдвэр гаргадаг жишгийг тогтооно.
4. Орон нутгийн ИТХ, Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг мэдээллийн бүхий л хэрэгсэл, олон нийтийн сүлжээг ашиглан тогтмол мэдээллэж, байнгын, бодит, өгөөжтэй эргэх холбоог бий болгоно.
5. Тухайн орон нутгийн иргэдийн хамтарч, хоршиж ажиллах аливаа санал, санаачлагыг дэмжиж ажиллана.
6. Иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай, хүнд сурталгүй, хялбар, энгийн ойлгомжтой болгох талаар төрийн захиргааны байгууллагууд болоод тухайн тойргоос сонгогдсон УИХ-н гишүүдтэй нягт хамтран ажиллана.
7. Нийтийн өмч, зам талбайн ашиглалт, хамгаалалт, эрүүл ахуйн нөхцөл байдал, орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтад тухайн орон нутгийн иргэдийн сайн дурын оролцоог эрс нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
8. Төв суурин газрын гудамж, орчны тоосжилтыг эрс бууруулах талаар иргэдийн оролцоонд суурилсан санаачлага гарган ажиллана.
9. Хүүхдийн тоглох, суралцах орчны эрүүл, аюулгүй орчныг хангах зорилтыг тэргүүлэх бодлого болгоно.
10. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс үзүүлдэг халамжаас гадна тухайн орон нутгийн иргэд хамтран сайн дурын үндсэн дээр нэгдэж халамж тусалцаа үзүүлдэг тогтолцоог хэвшүүлэх ажиллагааг санаачлан эхлүүлнэ.